

## УУРХАЙД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

201.....

№

Улаанбаатар хот

Энэхүү Хамтран ажиллах гэрээ- \цаашид "Гэрээ" гэж товчлох\ - г нэг талаас: Монгол Улсын "....." ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал ..... (цаашид "А" тал гэх), нөгөө талаас: "....." ХХК төлөөлөн Гүйцэтгэх захирал ..... (цаашид "Б" тал гэх) нар нь \цаашид хамтад нь "Талууд" гэх \ Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон, харилцан ашигтай, хамтран ажиллах зарчимд тулгуурлан байгуулав.

### Нэг. Хамтын ажиллагааны хүрээ, нөхцөл

1.1. А, Б талууд Монгол улсын иргэний хууль, Газрын тухай хууль болон холбогдох уул уурхайн нөөцийг олборлох, газар ашиглах тухай хууль, тогтоомжийг үндэслэн харилцан ашигтай, хамтран ажиллах зорилгоор ..... аймгийн ..... сумын ..... байрлах ..... дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, уурхайд хамтран олборлолт явуулахаар хэлэлцэн тохиролцож, түүнтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг энэхүү гэрээгээр зохицуулав.

1.2. А тал гэрээгээр хүлээсэн үүргээ хүлээж, өөрийн хууль ёсны эзэмшлийн талбайг Б талтай хамтран ашиглах, Б талын олборлолтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

1.3. Б тал Гэрээнд заасны дагуу **ашиглалтын** төлбөрийг төлөх, уурхайн олборлолтыг явуулж, ашиг олох зэргээр хамтран ажиллана.

1.4. ....

1.5.

### Хоёр. Хамтран ажиллах уурхайн өмчлөлийн эрхийн баталгаа

2.1. Тус уурхай нь алтны шороон орд болно.

2.2. А тал нь уурхайн ашигт малтмалыг болоод холбогдох эд хөрөнгийг эзэмших хууль ёсны эрхтэй болохоо баталж байна.

2.3. ....

### Гурав. Хамтын ажиллагааны хэлбэр

3.1. А тал нь гэрээнд заасан хугацааны турш уг уурхайн нөөц газарт Б талтай хамтран олборлолт хийх, хамтран ажиллах төсөл хэрэгжүүлнэ.

3.2. Хамтран ажиллах хугацаанд А, Б талууд дур мэдэн дангаар гэрээг цуцлах эрхгүй. Хэрэв аль нэг тал гэрээг цуцалбал нөгөө талдаа үүссэн хохиролыг 2 дахин нөхөн төлөх болно.

3.2. ....

### Дөрөв. Ашиг хувиарлах

4.1. Дээрх уурхайн төсөлд хэрэгжүүлж, хамтран ажилласнаас олсон ашгийг Б тал хуваарилах бөгөөд А тал 30%-ийн, Б тал 70%-ийн ашиг хүртэнэ.

4.2. Хамтын үйл ажиллагааны үр дүн, алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн хариуцлагыг талууд дараахь зарчмаар хариуцна: (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно)

- хувь тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
- хэсгээр өмчлөх хувь хэмжээний дагуу хариуцна.

*Үргэлжлэл бий .... /5х/*